

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил.....	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	5
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.12. Шилэн дансны мэдээлэл	8
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	8
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3. Менежментийн захидал	10
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	12
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	12
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	14
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	17
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	20
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	21
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	23
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	24

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН
ҮНДЭСНИЙ ЛАВЛАГАА ЛАБОРАТОРИЙН
ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ Б.АМАР ТАНАА

2020.02.27 № 06/624
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих, нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн ерөнхий захирал Б.Амар .. Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой холбогдох заавар журмыг мөрдөж ажиллах, өмнөх аудитаар өгөгдсөн албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлэх зөвлөмжийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 11 дүгээр сарын 12-ноос 2020 оны 02 дугаар сарын 17-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “Энич Аудит” ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 1 дүгээр сарын 21-ний өдрийн А/19 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь Монгол Улсын хэмжээнд хүн амын эрүүл ахуй, аюулгүй орчинд амьдрах, чанартай хүнс, бараа бүтээгдэхүүн хэрэглэх нөхцөлийг бүрдүүлэхэд тавих төрийн хяналт шалгалтын ажлын үр дүнг бие даасан, хараат бус магадлан шинжилгээний дүнгээр баталгаажуулан хангаж, лабораторийн үйл ажиллагааг олон улсын түвшинд хүргэхэд оршино.

Үйл ажиллагааны чиглэл: Засгийн газрын 2013 оны 330 дугаар тушаалаар батлагдсан “Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн ажиллах журам”-аар үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн дэх эрсдэлийн түвшинг үнэлэх
- Лабораторийн шинжилгээний мэдээллийн нэгдсэн санг удирдах
- Итгэмжлэгдсэн лабораториудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, тэдгээрт мэргэжил, арга зүйн удирдлага, дэмжлэг үзүүлэх, шинжилгээний дүнгийн нийцмэл байдлыг хангах
- Шинжилгээний дүнтэй холбоотой маргаан, хүсэлтийг хянах, баталгаажуулах, эцэслэн шийдвэрлэх арга хэмжээ авах, холбогдох төрийн захиргааны байгууллагад дүгнэлт, зөвлөмж гаргах

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Емералд” программ хангамж ашигладаг байна.

Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 28 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны эхний хагас жилийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 3,524,269.8 мянган төгрөгөөс тооцон 70,485.4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 110,514.7 мянган төгрөгөөр тооцсон нь 2019 оны жилийн эцсийн тайлангийн санхүүгийн үр дүнгийн нийт зардлыг сонгосонтой холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,666,437.0 мянган төгрөгөөр буюу 7.8 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	10.0	10.0	-
Авлага	30,809.4	24,275.9	/6,533.4/
Бараа материал	646,571.0	621,882.6	/24,688.4/
Үндсэн хөрөнгө	16,841,413.6	15,206,198.5	/1,635,215.1/
Нийт хөрөнгө	17,518,804.1	15,852,367.1	/1,666,437.0/
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,560,500.8	2,560,500.8	-
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	17,518,804.1	15,852,367.1	/1,666,437.0/

Авлагын дансны үлдэгдэл буурсан нь тайлант хугацаанд цайны газрын түрээсийн авлагыг 2,440.8 мянган төгрөгөөр, бүтээгдэхүүний шинжилгээний авлагыг 4,092.6 мянган төгрөгөөр барагдуулсантай холбоотой байна.

2019 оны жилийн эцсийн байдлаар үлдэгдэлтэй байгаа 24,275.9 мянган төгрөгийн авлага нь 2009-2011 онуудад үүссэн эзэн холбогдогчгүй иргэн, ААНБ нь татан буугдаад авах боломжгүй болсон авлагын үлдэгдэл байна.

Бараа материалын дансны үлдэгдэл буурсан нь 2019 онд эмийн зардлын төсөв өмнөх оноос 30.0 сая төгрөгөөр буурч батлагдсантай холбоотойгоор бараа материалын худалдан авалт тодорхой хэмжээгээр багассан.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл ТӨБЗГ-ын 2019 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн А/2531, А/2532 албан тоотуудаар 75,714.6 мянган төгрөгийн хөрөнгийг балансаас балансад шилжүүлсэн, 221,272.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө акталж, нийт 296,986.7 мянган төгрөгөөр хөрөнгө буурсан байна.

Тайлант онд 283,256.8 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан, мөн үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл 1,994,044.4 мянган төгрөг болж хасагдсанаар нийт хөрөнгийн дүн 1,666,437.0 мянган төгрөгөөр буурсан.

Биет бус хөрөнгө өссөн нь өмнөх онд хангамжийн материалын дансанд бүртгэлтэй байсан 129,990.0 мянган төгрөгийн программ хангамжийг биет бус хөрөнгийн данс руу шилжүүлсэнтэй холбоотой байна.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори нь тайлант онд 202,955.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 780,312.5 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 384.5 хувиар биелүүлсэн байна.

Шинжилгээний орлого 577,357.5 мянган төгрөгөөр давсан нь иргэн, ААНБ-ын шинжилгээ хийлгүүлэх захиалга болон улсын байцаагч нарын хяналт шалгалтын сорилын шинжилгээний дээж нэмэгдсэнтэй холбоотой байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 4 хөтөлбөрт зориулан 2,106,893.7 мянган төгрөгийн урсгал зардлын төсөв батлагдсан байна.

Нийт зардлын 1,903,938.7 мянган төгрөгийг улсын төсвөөс, 202,955.0 мянган төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,099,551.2 мянган төгрөг буюу 99.6 хувьтай байгаа нь байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж болон бараа үйлчилгээний бусад зардал, бусад урсгал шилжүүлгийн хэмнэлтээс шалтгаалсан байна.

Нэмэлт төсөв: Дээд шатны төсвийн захирагчаас орлогоор 432,000.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 90.0 мянган төгрөг, нийт 432,090.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс үндсэн цалин хөлсний зардалд 60,000.0 мянган төгрөг, хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардалд 25,000.0 мянган төгрөг, багаж тоног төхөөрөмжийн зардалд 87,000.0 мянган төгрөг, эм бэлдмэл, эмийн хэрэгслийн зардалд 44,000.0 мянган төгрөг, урсгал засварын зардалд 27,997.0 мянган төгрөг, тавилга хэрэгслийн зардалд 26,976.0 мянган төгрөг, бусад нийтлэг ажил үйлчилгээний хураамжинд 33,999.1 мянган төгрөг, мэдээлэл технологийн зардалд 4,795.0 мянган төгрөг, тоног төхөөрөмжийн зардалд 39,927.6 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалд 82,200.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 81.0 мянган төгрөг, нийт 431,975.7 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 114.3 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 25 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 3 эрсдэл тодорхойлж нийт 28 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 42,754.3 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 487.5 мянган төгрөгийн зөрчилд акт тогтоож, 12,522.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 29,744.7 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө. Үүнд:

1. Нэр бүхий 3 албан тушаалтанд 487.5 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон нь Ерөнхий захирлын 2016 оны А/03 тоот тушаалаар батлагдсан "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 9.10 дахь заалт "Сахилгын шийтгэл хүчинтэй байх /1 жил хүртэл/ хугацаанд энэхүү журамд заасан шагнал, урамшууллыг олгохгүй бөгөөд ур чадварын нэмэгдлийг бууруулан олгоно..." гэж заасантай нийцэхгүй, хэмжилт, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

2. Тайлант онд 12,522.0 мянган төгрөгийн тээвэр шатахууны тооцоо хийж, тайлан гаргаагүй байна.

Энэ нь Сангийн сайдын 2017 оны 247 тоот тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягыг нөхөх зааврын 6.4-д "Жолоочийн тооцооны хуудас НХМаягт ТМ-4 маягтын дагуу тооцоог бодно" гэсэн заалттай нийцэхгүй, эрх ба үүрэг, хэмжилт, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

Аудитаар илэрсэн 29,744.7 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Жил бүр давтагддаг тогтмол шинж чанартай үндсэн үйл ажиллагааны орлогыг өмнөх жилүүдийн гүйцэтгэлд үндэслэн бодиттойгоор тооцож төлөвлөдөггүй байна.

Тайлант онд төсөвт байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг 202,955.0 мянган төгрөгөөр төлөвлөж, 577,357.5 мянган төгрөгөөр буюу 284.5 хувиар давуулан биелүүлсэн ба цаашид анхаарч орлогыг үндэслэлтэй төлөвлөх нь зүйтэй гэж үзлээ.

Хан-Уул дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 183/ШШ2019/02597 тоот шийдвэрээр нэхэмжлэгч Ш.Сонинхүүд ажилгүй байсан хугацааны нөхөн олговрыг хариуцагч Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораториор гаргуулахаар шийдвэрлэсний дагуу 7,593.1 мянган төгрөгийг олгосон асуудлыг дараагийн аудитаар авч үзэх шаардлагатай.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 113 мэдээллийг хугацаанд нь, 16 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 4,021.6 мянган төгрөгийн төлбөрийн актыг барагдуулсан, 209,684.2 мянган төгрөгийн зөрчлийг арилгахаар албан шаардлага хүргүүлснээс 186,140.4 мянган төгрөгийн 2 албан шаардлагыг хэрэгжүүлсэн, мөн 23,543.8 мянган төгрөгийн авлагыг барагдуулахаар ажиллаж байна.

Нийт 2 зөвлөмж өгснөөс 2 зөвлөмжийг хэрэгжүүлсэн буюу зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Тайлант онд 16 ажил гүйлгээг бүрдэл дутуу баримтаар хийж, бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй, хэмжилт, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Эрсдэл:

Хууль тогтоомж зөрчигдөх, ажил үйлчилгээг буруу бүртгэх, тайлан буруу илэрхийлэгдэх

1.3. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, журам зааврыг мөрдөж ажиллах

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчлийг байгууллагын дарга, нягтлан бодогч нар хүлээн зөвшөөрсөн.

2. Орлогын данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Шинжилгээний төлбөрийн мэдээг орлогын бүртгэлтэй тулгахад 133.3 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2 дахь заалт "Санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг

хугацаанд нь, үнэн зөв ... бүртгэж, тайлагнах", Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан "Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын 2 дугаар зүйлийн "Орлогыг хүлээн зөвшөөрөх ба хэмжих" хэсэг: "Үйлчилгээний орлогыг холбогдох хууль тогтоомж заавар, гэрээнд заасан төлбөр ногдуулах журмын дагуу төлбөрийн хувь хэмжээ, төлөх хугацаа болон төлбөр хийсэн баримтыг үндэслэн бүртгэнэ" гэж заасантай нийцэхгүй, хэмжилт, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2. Эрсдэл:

Өөрийн үйл ажиллагаанаас бэлэн мөнгөөр орсон орлогыг санаатай болон санамсаргүйгээр бүртгэлд тусгахгүй, орхигдуулах, ашиглах, шамшигдал үүсэх.

2.3. Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6.3.2 дахь, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан "Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар" – ын 2 дугаар зүйлийг мөрдөж ажиллах

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчлийг байгууллагын дарга, нягтлан бодогч нар хүлээн зөвшөөрсөн.

3 Зардлын данстай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Өмнөх аудитаар өгөгдсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаж байгаа боловч 2009-2011 онд үүссэн 58 харилцагчийн 23,543.8 мянган төгрөгийн шинжилгээний төлбөрийн авлагыг барагдуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалттай нийцэхгүй, эрх ба үүрэг, оршин байх, үнэлгээ, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2. Эрсдэл:

Авлага, өр төлбөрийн дүн буурахгүй байх, бүртгэлээр тавих хяналт сулрах

3.3. Өгсөн зөвлөмж:

Аудитаар өгөгдсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллах, авлагыг барагдуулах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллах

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчлийг байгууллагын дарга, нягтлан бодогч нар хүлээн зөвшөөрсөн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ийн өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	677,390,518.42	646,168,604.98
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	10,000.00	10,000.00
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	10,000.00	10,000.00
31110	Төгрөг	10,000.00	10,000.00
33	АВЛАГА	30,809,425.02	24,275,965.02
335	Бусад авлага	30,809,425.02	24,275,965.02
3351	Байгууллагаас авах авлага	23,543,725.02	24,275,965.02
3352	Хувь хүмүүсээс авах авлага	7,265,700.00	
35	БАРАА МАТЕРИАЛ	516,581,093.40	621,882,639.96
351	Түүхий эд материал	178,983,491.13	188,842,287.99
35110	Тусгай зориулалттай материал	28,384,919.41	81,714.29
35130	Эм боох материал	150,598,571.72	188,760,573.70
354	Хангамжийн материал	336,466,202.42	431,908,952.12
35410	Бичиг хэргийн материал	20,859,877.85	14,260,814.22
35420	Аж ахуйн материал	15,027,932.74	21,027,869.81
35430	Сэлбэг хэрэгсэл	89,161,381.00	127,526,343.18
35470	Бусад хангамжийн материал	211,417,010.83	269,093,924.91
35600	Мал амьтад	1,131,399.85	1,131,399.85
36	НӨӨЦИЙН БАРАА	129,990,000.00	-
36700	Бусад санхүүгийн хөрөнгө	129,990,000.00	
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	16,841,413,614.88	15,206,198,497.04
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	16,841,413,614.88	15,206,198,497.04
392	Биет хөрөнгө	16,568,801,977.78	14,805,831,268.37
39201	Барилга, байгууламж, орон сууц	12,104,050,304.00	12,104,050,304.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	1,004,083,684.88	1,215,299,559.83
39203	Авто-тээврийн хэрэгсэл	108,436,620.00	147,936,620.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	96,627,209.88	101,155,601.17
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	13,626,100,217.87	13,561,854,035.05
39206	Хуримтлагдсан элэгдэл	8,733,587,067.56	10,112,111,720.37
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	1,326,521,352.69	1,337,537,666.65
39208	Хуримтлагдсан элэгдэл	807,424,940.60	961,564,100.00

39214	Бусад үндсэн хөрөнгө	50,000,000.00	50,000,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	4,583,613.86	5,416,375.96
393	Биет бус хөрөнгө	272,611,637.10	400,367,228.67
39301	Програм хангамж	137,046,000.00	152,359,800.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	18,034,362.90	35,048,804.58
39303	Бусад биет бус хөрөнгө	153,600,000.00	283,590,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-	533,766.75
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	17,518,804,133.30	15,852,367,102.02
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	17,518,804,133.30	15,852,367,102.02
51	Засгийн газрын хувь оролцоо	17,518,804,133.30	15,852,367,102.02
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,560,500,816.70	2,560,500,816.70
512	Хуримтлагдсан үр дүн	14,882,727,910.07	13,216,290,878.79
51210	Өмнөх үеийн үр дүн	16,419,991,421.24	14,882,727,910.07
51220	Тайлант үеийн үр дүн	(1,537,263,511.17)	(1,666,437,031.28)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	75,575,406.53	75,575,406.53
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	17,518,804,133.30	15,852,367,102.02

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ийн өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,510,204,766.00	3,859,297,039.68
110002	Үйл ажиллагааны орлого	1,013,380,653.00	1,523,358,339.68
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,013,380,653.00	1,523,358,339.68
120	Нийтлэг татварын бус орлого	1,013,380,653.00	1,523,358,339.68
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,013,380,653.00	1,522,972,539.68
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,002,598,373.00	1,209,536,537.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,322,280.00	6,101,900.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	2,460,000.00	307,334,102.68
120009	Бусад орлого		385,800.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,496,824,113.00	2,335,938,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,984,793,900.00	1,903,938,700.00
